

ДОРНОД СИБИРЬ, АЛС ДОРНОДЫН БҮС НУТГИЙН НЕФТЬ, ХИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙГ ЗҮҮН АЗИЙН ЗАХ ЗЭЭЛТЭЙ УЯЛДУУЛАХ АСУУДАЛД

*К.Дэмбэрэл**

“Нефть” гэдэг үг нь арабын “нафата” гэдэг үгнээс, “газ буюу хий” нь грекийн “хаос” гэсэн үгнээс тус тус гаралтайг нэвтэрхий толинд тэмдэглэсэн. Нефтийн химийн найрлаганд нүүрстөрөгч 79-88 хувь, устөрөгч 11-14 хувь, хүхэр 8 хүртэл хувь, азот 1-2 хувь, хүчилтөрөгч 1 хүрэхгүй хувь, янз бүрийн металлууд 0,03 хувь орчим байдаг юм байна. Харин шатдаг хий буюу байгалийн хийн химийн найрлагад метан 99,5 хувь, бусад нь этан, пропан, бутан, пентанагаас гадна гели, азот өчүүхэн хэмжээтэй байдаг.¹ Нэг кг нефтийг шатаахад 42-47 мега.жоуль дулаан, хийг шатаахад 38-40 мега.жоуль дулааныг тус тус ялгаруулдаг. Эдгээр тоо бол аливаа түлшний хувьд дулаан ялгаруулалтаар хамгийн өндөр үзүүлэлт. Энэ утгаараа нефть, хийн эрчим хүчний үндсэн эх сурвалж болдог юм байна. Нефть, хийн дараагийн нэг чухал зүйл бол бүхий л химийн үйлдвэрийг хөгжүүлэх нэг үндэс аж. Тэдгээрийн үүсэл, гарлыг эрдэмтэд олон янзаар тайлбарлаж ирсэн. Бидний хувьд эдгээр бодисыг химийн найрлага талаас нь судлах гэсэндээ дээрх тоонуудыг бичсэнгүй. Харин өнөө үед нефть, байгалийн хийн асуудлаар “олон судлаачид” бичих, судлах болсон хэдий ч тэдгээрийг улс төр, эдийн засгийн бодлогын хүрээнд судлаж байгаа хүмүүс маань дээрхи тоонууд, химийн нэр томъёоны талаар дэндүү хомс мэдлэгтэйгээр зарим асуудалд хандаж байгаа нь энэхүү өгүүллийг ийм байдлаар эхлэхэд хүргэсэн болно. Нефть, хий нь байгаль дээр ямар хэлбэрээр оршдог, ямар өнгө, амт, үнэртэй, хэрхэн олборлодог, яаж, ямар хэлбэрээр хэрэглэгчдэд хүрдэг талаархи танин мэдэхүйн зарим асуудлаа орхиод үндсэн “судалгаандаа” хандъя.

Энэхүү судалгаанд ОХУ-ын нефть, хийн салбарын томоохон бүс болох Дорнод Сибирь, Алс Дорнодын бүс нутгийн нефть, хийн нөөцийн ерөнхий төлөвөө хэрхэн тодорхойлж байгаа, мөн Зүүн Азийн зах зээлд хэрхэн ойртох бодлого барьж буйг тандахыг зорилоо.

ОХУ-ын эрчим хүчний эх сурвалжийн үндсэн зах зээлийг тоймолбол:

Зүүн Европ /Чех, Словак, Польш, Герман/ 25 орчим хувь, Их Британи, Ирланд 25%, Газар дундын тэнгисийн улсууд /Грек, Кипр, Турк, Болгар/ 25%, Баруун Европын улсууд /Австри, Швейцарь, Швед,

* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор (Ph.D)

Дани, Финлянд, Бельги/ 20%, АНУ, Канад 7%. ОХУ-ын хувьд Европын зах зээлд нийлүүлэх тээвэрлэлтийн асуудал харьцангуй шийдэгдсэн. ЗХУ-ын худалдааны флотын 57%-ийг Орос улс өвлөн авсан. ОХУ-ын дамжуулах хоолойн нийт тууш урт нь 210 мянган км ба түүгээр ачаа эргэлтийн 52,5% нь хийгддэг.

ОХУ нь Европ гэсэн ганц зах зээлээс одоохондоо хэт хамааралтай байгаа. Ганц хэрэглэгчээс хамааралтай байгаа байдлыг өөрчлөх эрмэлзэл төрийн ч хувьд компаниудын удирдлагын хэмжээнд бий боллоо. Эрмэлзлэлээ хэрэгжүүлэх боломжийн нэг бол Дорнод Сибирь, Алс Дорнодын нефть, байгалийн хийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, улмаар Зүүн Азийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг харгалзан тэнд зах зээлээ өргөжүүлэх явдал юм байна. ОХУ-ын статистикийн газар, ШУА-ийн тооцоолсноор түүний байгалийн нийт нөөц баялаг 340-380 трлн ам.доллараар үнэлэгдэж байгаа. Урьдчилсан байдлаар дэлхийн нефтийн нөөцийн 13%, байгалийн хийн 42%, нүүрсний 43% нь, олборлолтын хувьд нефтийн 11%, хийн 28%, нүүрсний 14% нь Орост ногдож байгаа. Түүхий нефть болон нефть бүтээгдэхүүн нь ОХУ-ын нийт экспортын 40 хувийг дангаар эзэлдэг. Ер нь дэлхийн түлш эрчим хүчний балансад нефть нь 35%-ийг эзэлдэг.

Оросын нефтийн хайгуулын нөөц нь 21,5 тэрбум тн, байгалийн хийн 48 орчим трлн.шоо м хэмээн тогтоогоод байгаа. Байгалийн хийн дэлхийн илэрсэн нөөцийн 33 хувь, түүний олборлолтын 28 хувь нь Орост ноогдож² байна. Ер нь нефть, хий бол олборлоод дундардаг ч зарим газар шинэ ордыг илрүүлэх ажил хийгддэг ч “лимиттэй” байгалийн баялаг. Энэ баялгийг хүн төрөлхтөн өнгөрсөн зуунаас эхлэн хамгийн эрчимтэй хэрэглэж эхэлсэн. Энэ зунд бараг л “гэрлийн хурдаар” ашиглах төлөвтэй. Нефтийг өнөөгийн хурдаар олборлох юм бол 40 жилийн дараа, байгалийн хий 80 жилийн дараа л гэхэд нөөцөө тус тус шавхана гэсэн зарим пессимист судлаачийн дүгнэлт ч бий. Дэлхийн хэмжээнд одоо ашиглаж байгаа ордуудаас олборлож байгаа нефть, хий жилд дунджаар 5 хувь хорогдож байгаа. Ер нь 2010 оноос хойших хэрэглээний нефть, хийн тэн хагас нь шинэ орд газрыг ашиглаж олборлоход хүрнэ.

Францын улс төр судлаач Ж.Тириар бичихдээ: “Бид Исланд Владивосток хоорондох орон зайд 800 сая хүн амыг төвлөрүүлэн 1200 сая хүн амтай Хятадтай сөрж чадах ба Сибирийн хөрсөн доорхи бүхий л зүйлс бидний эрчим хүчний хэрэглээг хангана” хэмээн шууд Европын эзэнт улсыг байгуулахыг уриалсан төдийгүй “Баруун Европын тэргүүний техник, технологи нь “Европын Сибирийн” аугаа их нөөц баялагтай

хосолсон үед бидний өөдөөс хэн ч дуугарч чадахгүй болно” хэмээн илэрхий бардамнаж Европын БН эзэнт улс гэсэн супер их гүрнийг байгуулахыг сануулсан. Харин Оросын өнөөгийн удирдлага “Би Оросыг хэзээ ч эрчим хүчний их гүрэн гэж нэрлэхгүй. Гэвч бид хэнээс ч дутахааргүй нөөцтэй. Бид үргэлж хариуцлагатай хөдлөх болно. “Их наймын” орнууд эрчим хүчний аюулгүй байдлыг зөвхөн хэрэглэгч бус мөн нийлүүлэгч хангаж байх ёстой гэдэг дээр санал нийлсэн”.³

ОХУ нь нефть, хийн томоохон ордуудыг түшиглэн эрчим хүчний нэгдсэн төвүүдийг бүсчилэх хэлбэрээр хөгжүүлж ирсэн. Энэхүү бодлогын хүрээнд Дорнод Сибирь, Алс Дорнодын нефть, хийн нэгдмэл систем бий болгохоор төрийн бодлогоо тодорхойлсон. Чухам энэ бүс нутаг хэр их нөөцтэй, боловсруулах үйлдвэрийн хөгжил, хэрэглээний зах зээл нь ямархуу байгаа, хэрэглэгчдэд хүргэх тээврийн асуудлыг яаж шийдэх талаар тодруулья.

Оросын эрчим хүчний нийт чадавхийн (нефть, хий, ус, нүүрс гэх мэтийг оруулаад) гуравны нэг нь Сибирыг оршдог. Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Эрчим хүчний хүрээлэнгийн судалгаагаар бол 21-р зуунд дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээний 30-40% нь Япон, БНХАУ, ЗӨА-д ногдоно. 1990 онд энэ үзүүлэлт 18 хувьтай байсан. Япон улсын Ойрхи Дорнодоос хэт хараат байдлыг задлах нэг боломж нь “хаяанд нь байгаа” Сибирийн эрчим хүчний нөөц баялаг хэдий ч Оросын эдийн засгийн тогтвортой байдлыг голлон анхаарч байна. 2015 он хүртэл эрчим хүчний хувьд хэрэглээ, үйлдвэрлэлээр нефть I байрт, нүүрс II байрт, байгалийн хий III байрт байх судалгаа байгаа.

ОХУ-д Дорнод Сибирь, Алс Дорнодын бүсийн эрчим хүчний үйлдвэрлэлийн үүрэг, эзлэх байр суурь 2003 оны байдлаар

Үзүүлэлтүүд	ОХУ	Дорнод Сибирь*	Алс Дорнод	Алс Дорнод, Зүүн Сибирь нийтдээ
Газар нутаг, сая. хав.дөр. км	17.1	4.1 (24.0)*	6.2 (36.2)	10.3 (60.2)
Хүн ам, сая	145.2	8.3 (5.6)	6.7 (4.6)	15.0 (10.2)
ДНБ**, трлн. руб.	7830.3	457.4 (5.8)	393.7 (5.0)	851.1 (10.8)
Олборлолт, үйлдвэрлэл				
нефть, млн.т	421.3	0.2 (0.05)	3.6 (0.9)	3.8 (0.95)
байгалийн хий, тэрбум шоо м	620.3	0.5 (0.08)	3.6 (0.6)	4.1 (0.68)
түүхий нефть боловсруулалт, сая.т	188.4	13.4 (7.1)	8.5 (4.5)	21.9 (11.6)

* хашилганд ОХУ-ын хэмжээний үйлдвэрлэлд бус нутгийн эзлэх хувь
 ** - 2001 оны байдлаар

Дорнод Сибирь, Алс Дорнодын бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги

Үзүүлэлтүүд	Он			
	2002	2005	2010	2020
ОХУ-ын хүн амд бүс нутгийн хүн амын эзлэх %				
Дорнод Сибирь	6.41	6.41	6.45	6.50
Алс Дорнод	4.90	4.90	5.00	5.10
ДНБ-ийн жилийн дундаж өсөлт %				
ОХУ		7.10	6.90	6.50
Дорнод Сибирь		6.90	7.10	6.80
Алс Дорнод		6.90	7.10	6.70
ОХУ-ын ДНБ-д бүс нутгийн эзлэх %				
Дорнод Сибирь	6.40	6.60	7.00	7.30
Алс Дорнод	5.10	5.20	5.50	6.00

Дорнод Сибирь, Алс Дорнодын бүс нутгийн эрчим хүчний хэрэглээний өсөлтийн динамик

Үзүүлэлтүүд	Он			
	2002	2005	2010	2020
Дорнод Сибирь				
Цахилгаан эрчим хүч, тэрбум.кВт.цаг	126	135-145	150-155	175-185
Дулааны эрчим хүч, сая.Гкал	133	140-145	145-155	175-185
Алс Дорнод				
Цахилгаан эрчим хүч, тэрбум.кВт.цаг	38	40-45	50-52	65-70
Дулааны эрчим хүч, сая.Гкал	71	75-77	79-82	90-95

Дорнод Сибирь, Алс Дорнодын бүсийн нүүрсустрөгчийн үйлдвэрлэлийн прогноз

Нүүрсустрөгч	Он				
	2003	2005	2010	2015	2020
Дорнод Сибирь					
Нефть, сая.т	0.2	10-15	20-25	30-32	35-39
Байгалийн хий, тэрбум шоо м	0.5	4.5	25-30	40-45	45-50
Алс Дорнод					
Нефть, сая.т	3.6	5-7	15-19	30-35	35-39
Байгалийн хий, тэрбум шоо м	3.6	5-6	18-21	25-30	43-48

Бүс нутгийн нүүрсустрөгчийн түүхий эдийн хэрэгцээ, түүний боловсруулах хүчин чадлыг найдвартай тогтмол хангаж байх нөхцлийг Сибирийн платформд орших Красноярск, Эрхүү, БН Саха улсын баруун хэсэг, мөн Сахаины шельфийн нөөц баялаг нь бүрдүүлж чадах юм.

Энэхүү Сибирийн платформд илэрсэн нөөцийг дараахи байдлаар тогтоогоод байна. Үүнд: байгалийн хий – 4,3 трлн.шоо м, нефть – 1,3 тэрбум тн. Сахаины шельфт байгалийн хий – 824 тэрбум шоо.м, нефть 264 сая.тн хэмээн тогтоосон. Илэрсэн нөөцийг ашиглан үйлдвэрлэлийн

эргэлтэд оруулсан тохиолдолд бүс нутгийн дотоод хэрэгцээг хангаад зогсохгүй Ази, Номхон далайн бүсийн орнуудад жилд дунджаар 30-40 сая.тн түүхий нефть, 70-80 тэрбум шоо.м байгалийн хий экспортлох боломжтой аж.

Нефть, хийн орд газрыг нүүрсустрөгчийн нөөцөөр нь доорхи байдлаар ангилдаг

Ордын төрлүүд	Нефтийн нөөц сая.тн, хийн нөөц тэрбум шоо. м
Жижиг	10 – аас доош
Дунд хэмжээний	10-30
Томоохон	30-70
Том	70-300
Асар их	300 дээш

Хэдийгээр бүс нутагт ихээхэн нөөц баялаг буй ч томоохон хэмжээний олборлолт хийгдэхгүй байгаа. Дорнод Сибирыг 0.5 тэрбум шоо.м байгалийн хийг олборлож байгаа.

Алс Дорнодын бүс нутагт байгалийн хийн олборлолт нь Саха улс, Сахалин мужийн хойд хэсэгт жилд дунджаар 3.0-3.6 тэрбум шоо.м-ийг олборлох боллоо. Нефтийг үйлдвэрлэлийн зориулалтаар Сахалин мужийн хойд хэсэгт жилд дунджаар 1.4-1.5 сая.тн-ыг сүүлийн жилүүдэд олборлож байгаа нь судлаачдын үзэж буйгаар хангалтгүй үзүүлэлт аж.

Бүс нутгийн үйлдвэрийн болон томоохон хотуудад 2010-2015 он гэхэд 17-22 тэрбум шоо.м байгалийн хийн хэрэглээ яаралтай үүсэх нөхцөл бүрдээд байгаа. Ер нь бүс нутгийг хийн хэрэглээнд шилжүүлэх явдал хөгжлийн стратегийн асуудал болоод байна.

2006 онд ОХУ болон Сибирийн нүүрсустрөгчийн зах зээлийн хувьд нефть, хийн талбайд геологи хайгуулын санхүүжилтыг нэмэгдүүлсэн ба газрын хэвлий ашиглагчдын хувьд геологи хайгуулыг идэвхжүүлсэн явдал юм.

2005 онд Сибирийн холбооны тойргийн хэмжээнд нийт 12 дуудлага худалдаа явагдсан бол 2006 оны эхний 6 сард гэхэд л 26 дуудлага худалдаа явуулжээ. Үүнтэй холбоотойгоор хайгуулийн болон нефть, хийн олборлох шинэ байгууламжид хөрөнгө оруулалт эрс өслөө. Ер нь компаниуд анх зарласан үнээс дахин илүү үнийг дуудлага худалдаанд санал болгож байгаа.

ОХУ-ын газрын хэвлийн тухай хуулийн өөрчлөлт нь нефть, хийн компаниудыг салбартаа нэмэлт хөрөнгө оруулах, шинээр орд газар

худалдан авах боломжийг олгож байна. Ашигт малтмалын олборлолтод татварын шинэ хөнгөлөлт болох 7 жил буюу 25 сая.тн олборлолт хийх хүртэл татвараас чөлөөлөх тухай асуудал нь шинэ ордыг эзэмших, мөн геологи хайгуулын ажилд хувийн секторын санхүүжилт хийх сонирхлыг нэмэгдүүлж байна. Хуулийн нэмэлт өөрчлөлт нь 2007 оноос мөрдөгдөнө.

Түүнээс гадна нэг чухал түлхэц бол Ази, Номхон далайг чиглэсэн хийн болон нефтийн хоолойг барьж эхэлж байгаа нь энэ чиглэлд үйл ажиллагаа идэвхжихэд нөлөөлсөн.

Оросын нефть олборлолтын хэтийн түвшин нь дэлхийн зах зээл үнийн динамик, дотоодын зах зээлийн эрэлт, орд газрын боловсруулалт, хайгуулын хувьд улсаас барих татварын нөхцөл, түүнчлэн хайгуул хийгдсэн түүхий эдийн ордуудын чанараар тодорхойлогдоно.

Дэлхийн зах зээлийн үнэ нь дэлхийн эдийн засгийн хөгжлийн хурдац, нефть орлох эрчим хүчний эх сурвалжийг бий болгох үйл явц, дэлхийн зах зээлд нефтийн нийлүүлэлт, түүнийг хэрэглэгчдэд хүргэх тээврийн асуудал зэргээр тодорхойлогдоно.

Нефтийн үнэд прогноз хийхэд дэлхийн нефтийн зах зээлийн нийтлэг шинжийг бүрдүүлэхэд нөлөөлдөг улс төр, эдийн засаг, технологийн хүчин зүйлүүдийг харгалзаж үздэг.

2010-2012 онд хүртэл нефтийн үнэ дэлхийн зах зээлд өндөр хэвээр хадгалагдах төлөвтэй бөгөөд тэрнээс цааш буурах хандлага нь 2006 оны сүүл, 2007 он гэхэд ажиглагдаж эхэлнэ. Хэтдээ Сибирийн холбооны тойрог, тухайлбал, Дорнод Сибирийн орд газруудын ашиглалт эхэлснээр Орост нефтийн олборлолт өсөх хандлагатай болно.

Сибирийн холбооны тойргийг одоо алс хэтдээ нефтьтэй байж болох мужуудад Томск, Омск, Новосибирск, нефть, хийн ирээдүйтэй Эрхүү, Красноярск, Эвенк, хийн ирээдүйтэй газар нутагт Таймыр хэмээн ангилах боломжтой.

Сибирийн холбооны тойргийн газрын хэвлийн агентлагийн мэдээгээр бол зөвхөн тойргийн хэмжээнд анх тогтоосон нефтийн нөөцийн хэмжээ 12,8 тэрбум тн, чөлөөт хий - 37,8 трлн шоо.м, ууссан хий - 1,09 трлн шоо.м, конденсат - 2,3 тэрбум тн хэмээн тодорхойлсон.

Хайгуулын нөөц нь $A+B+C1+C2$ гэсэн ангиллаар нийт нефть нь 1,6 млрд.тн бол байгалийн хийн 6,1 трлн куб. м.

Хайгуулын нөөцийн түвшин нь 13%, байгалийн хийн 11%-иар үнэлэгдэж байгаа нь тойргийн хэмжээнд геологи хайгуулын ажил сул хийгдсэн гэсэн үг. 2006 оны байдлаар тойргийн нутаг дэвсгэр дээр улсын тэнцэлд 144 орд газар тоологдсноос нефтийнх 89, хийн 12 орд байсан.

Үйлдвэрийн зориулалтаар А+В+С1 ангиллын нийт нөөц нь 216 сая.тн нефть бүхий 23 орд газрыг ашиглаж байгаа нь тойргийн хэмжээний нефтийн тогтоогдсон нөөцийн 29% болж байна. Харин байгалийн хийн хувьд бол 11 орд газраас олборлолт хийгдэж байна.

Сибирийн тойргийн нутаг дэвсгэр дээр олборлож байгаа нефть нь ОХУ-ын нийт олборлолтын дөнгөж 3% бөгөөд энэ нь үндсэндээ зөвхөн Томск мужид ноогдож байна. 2005 оны эцсийн дүнгээр үзэхэд нефть олборлолт тойргийн хэмжээнд 12,7 сая.тн, байгалийн хий - 5,1 тэрбум шоо.м байлаа. Олборлолт явуулж буй компаниудын олборлолтын жилийн дундаж түвшингээс харахад нефть, хийн нөөц нь тэдгээрийн үйл ажиллагаанд 22-100 жил хүрэлцэхүйц юм.

Нефть, хийн нөөцийн өсөлт түүнийг ашиглаж буй үйл явц нь эерэг хандлагатай байгаа. Өөрөөр хэлбэл, олборлолт илрүүлэлт хоёр эерэг харьцаатай байна гэсэн үг. Тухайлбал, 2000-2004 онуудад тойргийн хэмжээнд нефтийн нөөцийн өсөлт 79,8 сая.тн байсан бол олборлолт 57,3 сая.тн, хийн хувьд 1,24 тэрбум шоо.м-ээр нэмэгдсэн бол олборлолт 0,02 трлн куб.м байх жишээтэй. Зөвхөн 2004 онд гэхэд 42 сая.тн нефтийн нөөцийг улсын тэнцэлд тусгасан бол 17 сая.тн-ыг олборлосон үзүүлэлт гарсан. Харин 2005 онд Томск мужид бүртгэлтэй “ЮКОС” нефтийн компанийн бүтцэд байсан үйлдвэрүүдэд өөрчлөлт хийгдсэнээр олборлолтын ажлын түвшин буурсан.

“Дорнод Сибирь-Номхон далай” нефть дамжуулах хоолой үндсэндээ Дорнод Сибирийн нефть байх ба улсын зүгээс, нэн ялангуяа, энэ нутаг дэвсгэр дээр хайгуулын ажил, ордыг эзэмших зэрэгт түлхэц өгөх замаар төслийг дэмжиж байгаа.

ОХУ-ын газрын хэвлийн ашиглалтын холбооны агентлаг нь 2005 оноос эхлэн газрын хэвлий, эрдэс түүхий эдийн баазын нөхөн үйлдвэрлэлийн судалгааны урт хугацааны хөтөлбөрийг идэвхтэй хэрэгжүүлж эхэлсэн.

2005 онд Сибирийн холбооны тойрогт улсын төсвөөс 1,6 тэрбум рублийн геологи хайгуулын ажил хийгдсэн. Тийм хэдий ч хувийн секторын санхүүжилт дээрх хэмжээнээс 4 дахин илүү буюу 6,9 тэрбум рубль болсон. 2004 онд улсын санхүүжилт 2,1 дахин нэмэгдсэн хэдий ч хувийн сектороос ерөнхийдөө илүү гарч чадахгүй байгаа. 2006 онд хувийн секторын хөрөнгө оруулалт улсынхаас 30%-иар илүү байх төлөвтэй. Нефть, хийн ордын нэг метр газрын өрөмдлөгийн үнэ өнөөгийн ханшаар 40 мянган рубль байгаа аж. Тийнхүү нэг орд газрыг бүрэн эзэмших нийт зардал ойролцоогоор 3-5 тэрбум рубль болж байна.

ОХУ-ын Засгийн газар нь олборлох үйлдвэрүүдээс улсын төсөвт төлөх татвар болох акциз, ашигт малтмалаас авах татварын хэмжээг тогтоодог. Сибирийн холбооны тойрогт “Роснефть”, “ТНК-ВР”, “Газпром”, “Сургутнефтегаз” гэсэн томоохон компаниуд судлагдаагүй нефть, хийн шинэ ордуудыг худалдан авч эхэллээ. ОХУ-ын “Газпром” компани нь улсын валютын орлогын 20%, улсын төсвийн 25%-ийг тус тус бүрдүүлдэг хамгийн том компани. “Газпром” нь сүлжээний хувьд дэлхийд хоёрт орох үндэстэн дамнасан корпораци. ОХУ-ын байгалийн хий олборлолт нь урьдчилсан байдлаар 2010 он гэхэд жилд 635-665 тэрбум, шоо метр, харин 2020 он гэхэд 680-730 тэрбум шоо метр хүрэх төлөвтэй. Бизнесийн таатай орчинд Дорнод Сибирь, Алс Дорнодод 2010 онд 50 тэрбум шоо.м, 2020 онд 110 тэрбум шоо.м байгалийн хий олборлох боломжтой аж.

Өнөөдөр Оросын дотоодын зах зээлд 1000 шоо.м хийн үнэ 50 ам.доллараас (1350 рубль) доош өөрөөр хэлбэл дотоодын зах зээлд хийн үнэ дэлхийн зах зээлийн үнийн 50%-иас доош үнээр борлогдож байгаа нь салбарын хөгжилд ч сөргөөр нөлөөлж байна. Тиймээс 2010 он гэхэд дотоодын зах зээлийн үнийг 59-64 ам.долларт хүргэх төлөвлөгөөтэй байна. ОХУ-ын хийн аж үйлдвэрийн үндсэн бааз нь ойрын ирээдүйд Баруун Сибирь хэвээр байх төлөвтэй.

Орост үйлдвэрийн болон ахуйн хэрэгцээнд зориулагдсан нефть, хийн бүтээгдэхүүний үнийн субсид нь дунджаар 3% байдаг.

2005 онд 1 баррель нефтийн үнэ дунджаар 50 ам.доллар байсан гэвэл 1 баррель нефтийн өртөг ямар байх вэ? Олборлолт нь 4 ам.доллар, тээвэрлэлт нь 2,5 ам.доллар, боловсруулалт нь 5 ам.доллар, зах зээлд хүргэх өөрөөр хэлбэл, хэрэглэгчдэд хүргэх 7 ам.доллар гэсэн зардал бий болдог. Мөн үйлдвэрлэгчид маань ашиг гэж нэг баррель тутмаас 4 ам доллар хүртэнэ. Ийнхүү 50 ам.долларыг задлаж үзүүлбэл: $4+2.5+5+7+4=22.5$ ам доллар. Эдгээрт нэмэгдээд үйлдвэрлэгч болон хэрэглэгч орнуудын засгийн газар нь татвар хэлбэрээр “ашиг” хүртэнэ.

Байгалийн хийн хангамж, тээвэрлэлт, олборлолтын нэгдсэн системийг Дорнод Сибирь, Алс Дорнодын бүс нутагт бүрдүүлэх хөтөлбөрийг ОХУ-ын Засгийн газрын даалгавараар “Газпром” компани боловсруулсан. Энэ хөтөлбөр нь Засгийн газрын хуралдаанаар дэмжигдэн цаашид нягтлан боловсруулах шатандаа Түлш, эрчим хүчний яаманд нарийвчлан судлагдаж байна. ОХУ-ын байгалийн хийн нийт нөөц 44,8 трлн.шоо метрээр тогтоогдоод байгаагаас Дорнод Сибирь, Алс Дорнодод 14,5 трлн.шоо метр ногдож байна. Бүс нутгийн

байгалийн хийн илэрсэн нөөц нь АНДБ-ийн ашиглагдаж буй орд газруудын нөөцөөс хавгүй илүү байгаа.

Дорнод Сибирь, Алс Дорнодод нефть, хийн 49 орд нээгдсэн ба прогнозоор бол нефтийн 50 орчим, хийн 170 гаруй орд дахиад нээгдэнэ. Эдгээрээс томоохон ордуудыг дурдвал: Ковыктинскийн байгалийн хийн орд - С1, С2 ангиллаар 1,97 трлн.шоо метрийн нөөцтэй. Чаяндинскийн нефть, хийн конденсатын орд - С1 ангиллаар 380 тэрбум тн нефть, С2 ангиллаар 861 тэрбум шоо метр хийн конденсатын нөөцтэй. Эдгээр 2 ордын нүүрсустөрөгчийн агуулгад гели харьцангуй ихээр илэрч байгаа нь тэдгээрийг улам үнэ цэнэтэй болгож байна. Юрубчено-Тахомск, Собинско-Пайгинскийн орд нь хийн олборлолтын 3 дахь том төв. Эвенкийн автономит тойргийн байгалийн хийн нөөц 9 трлн.шоо метрээр үнэлэгдэж байгаа ба С1 ангиллаар 290 тэрбум шоо метр, С2 ангиллаар 719 тэрбум шоо метрт хүрч буй. Одоо байгаа тогтоосон нөөцдөө түшиглээд Ковыктинскоос 31 тэрбум шоо метр, Чаяндинскоос 22 тэрбум шоо метр, Юрубчено-Тахомскоос 18 тэрбум шоо метр хийг жилд олборлох боломжтой хэмээн мэргэжилтнүүд тооцоолжээ. Ер нь Дорнод Сибирийн газар нутгийн зонхилох талбайг (нефть, хий илрэх магадлалтай 3,3 сая хав.дөр.км талбайтай) эзлэх Эрхүү мужид байгалийн хийн нөөцийг 8,4 трлн.шоо метр хэмээн урьдчилсан байдлаар үнэлсэн. Үүнээс зөвхөн 1,6 трлн.шоо метрийг л тогтоосон. Кузнецкийн сав газарт нүүрсний метаны нөөцийг 13 трлн.шоо метрээр урьдчилсан байдлаар үнэлээд байгаа. Эндээс жилд 17-20 тэрбум шоо метрийг олборлох боломжтой.

2003 оны байдлаар Дорнод Сибирьт үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахаар 1,8 трлн.шоо метр байгалийн хийн нөөцтэй 15 орд, 396,2 сая.тн нефтийн нөөц бүхий 7 орд, Сахалины шельфын хэсэгт нефтийн 292 сая.тн, хийн 0,9 трлн.шоо метр нөөцтэй 6 том ордуудыг тус тус бэлтгэсэн.

Алс Дорнодод анхны ордыг нээснээс хойш өнөөгийн нээгдээд буй 71 ордыг хүртэл 60 илүү жилийн хугацаа өнгөрсөн. Эдгээрээс томоохон нь Одопту, Охотск, Притихооканск,

Дорнод Сибирь, Алс Дорнодын бүс нутаг нь түүхий нефть, нефть бүтээгдэхүүний томоохон хэрэглэгч өөрөөр хэлбэл, энд Ачинск, Ангарск, Хабаровск, Комсомольск-на-Амур гэсэн жилд 40 сая.тн түүхий нефть боловсруулах хүчин чадал бүхий боловсруулах үйлдвэрүүд бий.

Сибирийн болон Алс Дорнодын холбооны тойрогт багтах 17 субъектууд жилдээ дунджаар 24 сая.тн нефть, 25 тэрбум шоо.м хийг

хэрэглэнэ. 2001 онд гэхэд Дорнод Сибирийн орд газруудаас 2 тэрбум шоо.м хий, 0,457 сая.тн нефть, Алс Дорнодод 110 сая.тн нефть, 40 тэрбум шоо.м хий олборлосон. Эдгээр бүс нутгийн бараг бүх районууд эрчим хүчний хомсдолтой.

“Газпром”-ын тооцоогоор бол 2020 он гэхэд Дорнод Сибирыг байгалийн хийн эрэлт хэрэгцээ жилд 17,8 тэрбум шоо.м, Алс Дорнодод 22,5 тэрбум шоо.м-т хүрэх юм байна.

Дорнод Сибирийн байгалийн хийн Баруун Сибирыг хэрэгцээтэй болж энэ чиглэлд 30 орчим тэрбум шоо м хий нийлүүлэх шаардлага бий болно.

Буриад, Читаг байгалийн хийгээр хангах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад тухайн субъектуудыг шингэрүүлсэн пропан-бутаныг Эрхүү мужийн Балаганск районд баригдах хийн боловсруулах үйлдвэрүүдээс төмөр замаар зөөвөрлөн хэрэглэгчдэд хүргэх нь үр ашигтай байна. Хийн хоолойг Эрхүү-Улаан-Үд-Чита гэсэн туслах хоолойгоор хүргэхэд тухайн бүсийн төлбөрийн чадвар даахааргүй өртөгтэй болох тул асуудлыг хойшлуулсан. Энэ бүсэд хийг ашиглах нь Байгаль нуурын экологийн тэнцвэрийг хадгалахад нөлөөтэй зүйл. Цаашдаа бүс нутгийг бүрэн “газжуулах”-д хийг хөдөлгүүрийн түлшинд ашиглах үйл явцыг тууштай хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн бүх түвшинд тодорхойлж байна. Оросын зарим субъектууд энэ талаар хууль ч гаргасан. Өнөө үед ОХУ-ын хэмжээнд тээврийн хэрэгслийг шатдаг хийгээр цэнэглэгч 207 станц баригдсан.

Зүүн Азийн орнууд, тухайлбал Япон, Өмнөд Солонгос, БНХАУ-ын хувьд байгалийн хийн эрэлт нь юуны өмнө, экологийн шалтгаантай, тодруулбал, байгаль орчинд хохирол багатайгаар эрчим хүчний хэрэглээг цаашид нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Байгалийн хийн хэрэглээний өсөлт нь үнийн болон найдвартай нийлүүлэлтээс ихээхэн шалтгаална. Хийн боломжийн нийлүүлэлт хангагдсан нөхцөлд эрэлт ч нэмэгдэх бүрэн боломжтой.

Зүүн Ази нь ойрын ирээдүйд өөрийн байгалийн хийн хэрэгцээгээ урьдын адил импортын шингэрүүлсэн хийгээр хангасаар байх болно. Тиймээс хийн нийлүүлэлтийн шинэ эх сурвалж зайлшгүй ойрын жилүүдэд эрэх болно. Энэхүү шинэ эх сурвалжид ОХУ-ын байгалийн хийн нийлүүлэлт орох нь зүйн хэрэг. Дорнод Сибирь, Саха Якут, Алс Дорнодын бүс нутагт илэрсэн болон нөөц нь тогтоогдсон томоохон ордуудыг түшиглэн хийн олборлолтын томоохон төвийг байгуулах ба тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх магистраль хоолойг байгуулах ажлыг эхлүүлээд байгаа. ОХУ-ын хамгийн зүүн хэсгийн хийн олборлолтын төв

нь Сахалины шельф бөгөөд 2010 он гэхэд энд 20 тэрбум шоо.м хийг олборлон 50%-ийг нь экспортлох төлөвлөгөөтэй байна. Хэтийн ирээдүйд 2010 оноос хойш хийн нийлүүлэлт Эрхүү мужаас Владивосток хүртэлх нутгийн хэрэглэгчдийг хийгээр хангаад зогсохгүй АНД бүсэд жил бүр 50 тэрбум шоо.м хийг нийлүүлэх боломжтой юм.

ОХУ-ын байгалийн хийн аж үйлдвэр гэдэг нь хуурай газар, далайн гүн дэх хийн ихээхэн нөөц бүхий орд газруудтай, Оросыг ТУХН-ийн улсууд болон Европтой холбосон хийн хангамжийн нэгдсэн систем бүхий евроазийн бүсэд геополитикийн ихээхэн ач холбогдолтой, энэ зууны олон улсын эрчим хүчний харилцааг бүрэлдүүлэхэд стратегийн хувьд нөлөөхүйц зүйл юм. Үүнийг зөвхөн хоёр тоогоор батлахад хангалттай. ОХУ нь дэлхийн байгалийн хийн нөөцийн 42 хувийг, олборлолтын 28 хувийг эзэлдэг. Олон улсын хийн зах зээл нь хэт бүсчилсэн шинжтэй хөгжиж байна. Өнөөдөр байгалийн хийн хувьд Хойд Америк, Европ, Зүүн Азийн гэсэн томоохон зах зээл бий болжээ. Ялангуяа, Зүүн Азийн байгалийн хийн зах зээл хөгжлийн шатандаа явж байна гэж үзэх үндэслэлтэй. Мөн Өмнөд Америк, Өмнөд Ази гэсэн хоёр том зах зээл бүрэлдэж байна. Дэлхийн эдийн засгийн интернационалчлагдах үйл явц, хийг алсын зайд тээвэрлэхэд бий болох шинжлэх ухаан, техникийн дэвшил яваандаа бүс нутгийн, тухайлбал, евроазийг хамарсан байгалийн хийн сүлжээ бүхий дэлхийн томоохон зах зээлийг бий болгох боломжтой. Энэ нь ОХУ-ыг газар зүйн байрлал, байгалийн хийн байршил зэргээр нь улам баталгаажуулж байна. Өөрөөр хэлбэл, Европ, Азийн хоёр зах зээл маань ОХУ-ын хийн аж үйлдвэрийг “горьдлын” нүдээр харсан байдалтай оршиж байна. Гэхдээ энэ хоёр зах зээл маань бүрэлдэн бий болсон байдал, хөгжлийн үе шат, цаашдын чиг хандлагаараа эрс ялгаатай байгаа. ОХУ нь Азийн зах зээлд байгалийн хийг экспортлохоос гадна тухайн бүс нутагт хийг олборлох өөрийн оролцоог бий болгох сонирхолтой. ОХУ нь Ямалын хагас арал дахь орд газрыг эзэмшснээр Хойд Америк, Өмнөд Америкийн зах зээлд шингэрүүлсэн хийг гаргах боломжтой болж байна.

Байгалийн хийн тээвэрлэлтийн асуудал нь олборлон нийлүүлэхэд чухал асуудал болж байна. Тиймээс тив дамнасан хийн нийлүүлэлтийн төслийг хэрэгжүүлэхэд улс хоорондын харилцааны шинэ хэлбэр бий болохыг үгүйсгэхгүй байгаа. Тухайлбал, тив хоорондын хийн урсгалд чухал нөлөөг хийн тээвэрлэлтийн транзитын төлбөр нэг гол асуудал болоод байгаа. Өнөө үед энэ төлбөр өндөр учир Европт гэхэд байгалийн хийн бусад түлштэй өрсөлдөх чадваргүй болж болох тал бий. Нэг гарц бол нийлүүлэгч, тээвэрлэгч хоёр ашиг хуваарилах хамтарсан механизм боловсруулах явдал. Хэрэглэгч,

нийлүүлэгч хоёр тал маань аль болох гуравдагч улсын дамжуулан тээвэрлүүлэх үйлчилгээг авахгүй байх сонирхолтой. Мөн үнийн хүчин зүйл, найдвартай байх гэсэн хоёр үзүүлэлт Оросын байгалийн хий, нефтийг Зүүн Азийн зах зээлд “ороход” чухал хүчин зүйл юм.

ОХУ-ын Түлш эрчим хүчний яамны тооцоогоор бол 2004 он хүртэл нефть олборлолтын хүрсэн түвшингээ хадгалахын тулд нефтийн аж үйлдвэрт жилд дунджаар 7-8 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байсан аж.

ОХУ-ын нефть, нефть бүтээгдэхүүний экспортын чадавхийг нэмэгдүүлэхэд техникийн шинэчлэл болон нефть боловсруулах үйлдвэрүүдийн гүний нефтийг дахин боловсруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор хүчин чадлыг нэмэгдүүлэх явдал. Одоогийн нефть боловсруулах гүнийг 62% байгааг 80% болгосноор (АНУ-д боловсруулалтын гүн 85% байдаг) даруй нэмэлт 40-42 сая.тн нефть бүтээгдэхүүн авах боломжтой юм. Тиймээс ОХУ-ын түлш эрчим хүчний салбарын нэг тулгамдсан асуудал бол нефть боловсруулах үйлдвэрүүдийг техникийн шинэчлэл хийх явдал юм. Тухайлбал, Орос нь хийг дахин боловсруулах хүчин чадал хангалтгүй улмаас жил бүр 30 сая.тн шингэрүүлсэн нефтийн хийг алдаж байгаа. Өнөө үед ОХУ нь хийн нийт олборлолтоос 12.5-15 илүүгүй хувийг дахин боловсруулж байна.

Алс Дорнод, Дорнод Сибирийн эрчим хүчний хөгжлийн прогноз нь бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн стратегийг тодорхойлж байна хэмээн үзэж болно.

2020 он гэхэд бүс нутгийн хөгжил нь тоон болон чанарын талаараа өнөөгийн европын дундаж түвшинд дөхөж очих боломжтой юм. Ингэхдээ, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн өсөлт Оросын дунджаас дээгүүр байж л хангана гэсэн үг. Түүнчлэн энэ бүс нутагт хүн амын өсөлт ч ажиглагдаж байгаа.

Сибирийн платформын нүүрсустөрөгчийг эрчимжүүлэн боловсруулах нь Дорнод Сибирийн дотоод хэрэгцээг хангахын зэрэгцээ экспортын хувьд таатай нөхцөл бий болгох юм. 2010-2020 он гэхэд Дорнод Сибирийн байгалийн хийн олборлолтын 65%-ийг, нефтийн 50-60%-ийг экспортод гаргахаар төлөвлөж байгаа. Харин Алс Дорнодын олборлолтын 70 орчим хувь нь энэ үед экспортод чиглэгдэх төлөвлөгөөтэй байгаа.

Дорнод Сибирьт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 2020 онд 2003 оньхоос 1.6 дахин, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл 1.5 дахин өсөх ёстой бол Алс Дорнодод энэ тоо 1.7, 1.3 гэсэн үзүүлэлттэй байх болно.

Түлшний үйлдвэрлэлийн өсөлт үндсэндээ байгалийн хий, нефть олборлолтын өсөлтөөр хангагдах төлөвтэй. Бүс нутгийн уурын зуухны түлшинд байгалийн хийг ашигласнаар тэдгээрийн бүтцийг сайжруулах боломжтой. Энэ нь Дорнод Сибирьт гэхэд 7% байснаа 15% болж өсөх бол мазутын хэрэглээ 5% байснаа 2% болж буурах юм. Гэсэн хэдий ч Дорнод Сибирьт нүүрсний хэрэглээ ойрын ирээдүйд өндөр -78%-хэвээр байх юм. Алс Дорнод ч ялгаагүй түүний хэрэглээ өндөр -57%- байна. Гэхдээ дээрхи тоонууд 2020 онд гэхэд байгалийн хийг ашигласнаар 2 дахин буурах ёстой.

ОХУ-ын Түлш эрчим хүчний яамны прогнозоор бол 2010 он гэхэд түүхий нефтийн экспорт 300 сая.тн хүрч нэмэгдэх төлөвтэй. Түүхий нефтийн экспортын өсөлтөд тээврийн асуудал саад болсоор байгаа. Нефть бүтээгдэхүүний экспортын гол саад нь түүний чанарын доод түвшин юм. 2005 оноос ЕХ-нд зайлшгүй мөрдөх болсон найрлагадаа хүхэр бага агуулсан дизель түлшний үйлдвэрлэлээр өнөө хэр хоцрогдсоор байна.

Оросын Дорнод Сибирь, Алс Дорнодын эрчим хүчний хурдтай, далайцтай хөгжил, тэдний ЗХА-ийн эрчим хүчний зах зээлд гарах үйл явц зэргийг ОХУ-ыг стратегийн хувьд Зүүн Азийн бүсэд найдвартай байр суурийг эзлүүлэх чухал түлхүүр мөн.

ОХУ-ын эдийн засгийн хөгжлийн яамны сайд Г.Грефын “ОХУ: эрчим хүч, бүтээн байгуулалт” бага хуралд тавьсан илтгэлдээ Дорнод Сибирийн шинэ орд газрын нефтийн олборлолтыг 2013-2014 оноос эхэлнэ хэмээн тэмдэглэсэн. Мөн түүний хэлснээр, сүүлийн жилүүдэд нефть олборлолтын салбарын өсөлтийн хурдац жилд 2-2.5 хувь хүртлээ буурсан. Энэ бууралтыг зөвхөн шинэ орд газрыг ашигласнаар зогсоох буюу өсгөх боломжтой аж. Гэхдээ энэ шинэ орд газрууд нь дэд бүтэц хөгжөөгүй, олборлолтын хүнд нөхцөлтэй газарт л боломжтой аж. ОХУ-ын Засгийн газар нь Дорнод Сибирь, Алс Дорнодын бүс нутагт нефть хайгуул, олборлолтын салбарт хөрөнгө оруулах компаниудыг дэмжих иж бүрэн арга хэмжээг боловсруулаад байгаа. Хууль эрхийн өөрчлөлтийг хийгээд байгаа. Энэхүү дэмжлэг нь одоо хэр тодорхой бус байгаа “Дорнод Сибирь-Номхон далай” чиглэлийн нефть дамжуулах хоолойн байгуулалтад чухал түлхэц болно гэж сайд тэмдэглэсэн. Эхний ээлжинд нефть дамжуулах хоолой Хятад руу тавигдах аж. Энэ хэсэгт мөн төмөр зам зэрэг барих ба түүгээр Номхон далайн эрэгт нефть нийлүүлэлтийг хангах юм.

ОПЕК нь дэлхийн нефтийн нийлүүлэлтийн 40 хувийг хянадаг, тэрээр үнийг барьж байхын тулд өдөрт 28 сая баррель нефть олборлох хэмжээнд барихаар төлөвлөөд байна.

ЗХА-ийн нефтийн үйлдвэрлэл, хэрэглээ 1999-2020 (сая.тн)

	Үйлдвэрлэл		Хэрэглээ		Импорт		Бусдаас хараат байдал, %	
	1999	2020	1999	2020	1999	2020	1999	2020
БНХАУ	159.9	151.9	204.3	497.5	44.4	345.4	21.7	69.5
Гонконг	0	0	11.2	23.9	11.2	23.9	100.0	100.0
Тайвань	0.4	0	38.2	51.1	38.2	51.1	99.9	100.0
Япон	0.7	0	266.4	288.4	265.7	288.4	100.0	100.0
Өмнөд Солонгос	0.4	0.4	99.9	163.0	99.5	162.6	99.6	99.7
ЗХА	164.4	152.3	620.0	1,023.9	459.0	871.4	-	-

Эх сурвалж: APEC Energy Demand and Supply Outlook 2002 (Токуо: APERC, 2002), 56.

Дээрх хүснэгтээс харахад 2020 он гэхэд ЗХА-ийн нефтийн импортод Оросын хувь 15-аас дээш гарч чадахгүй байгаа нь Япон зэрэг орнуудыг ихэд эмзэглүүлэхгүй болов уу. Одоо яригдаж буй нефть дамжуулах хоолойг ашиглаж эхэлснээр жилд Хятадын чиглэлд 30 сая.тн, Находка чиглэлд 50 сая.тн, Сахалины төслөөр нэмж 25 сая.тн-ыг гаргасан тохиолдолд ЗХА-д 12-13 хувийн экспорттой байх боломжтой. Дотоод хэрэгцээ, экспорт хоёроо бодвол Дорнод Сибирь, Алс Дорнодод 150 сая орчим тн түүхий нефть олборлох шаардлагатай аж. Өнөө үед жилд зөвхөн 3 сая.тн-оор хязгаарлагдаж байна.

БНХАУ-ын байгалийн хийн хэрэглээ харьцангуй бага байгаа нь ЗХА-ийн импорт нэмэгдэхгүй байх нэг нөхцөл. Тус улс жилд 5 тэрбум шоо.м хийг хэрэглэж байгаа нь Японы нэг мужийн дайтай тэнцэхүүд зүйл. Хятадад хийг ихэнхдээ үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байна.

Нефть дамжуулах хоолойн “урт настай” төслүүд

Чиглэл	Санхүүжилтийн эх үдсвэр	Төслийн нийт өртөг	Хэрэгжих хугацаа	Хүчин чадал
Ангарск - Забайкальск - Дацин	1. ЮКОС-ын өөрийн хөрөнгө, ирээдүйн орох орлогоор барьгаалсан банкны зээл, 2. Оросын хэсгийн санхүүжүүлэх Хятадын зээл 3. Транснефть бонд гаргах эсвэл улсын зохих санхүүжилт	2,2-2,5 тэрбум ам.доллар гэсэн үнэлгээтэй	2005 он	600 мянган баррель өдөрт буюу 30 сая.тн нефть жилд
Ангарск - Находка	Японы зээл, японы даатгалын баталгаа	5-5,2 тэрбум ам.доллар	2008 он	өдөрт 1000 мянган баррель буюу жилд 50 сая.тн нефть

Эх сурвалж: Дейта.RU 29 июня 2003

Нүүрсустөрөгчийн баялаг нөөц бүхий субъектын нэг болох Саха (Якут) улс нь меридианы дагуу чиглэсэн 1500 км урттай дамжуулах хоолойг АНД-н бүсэд гаргах байр суурьтай байгаа. Ингэхдээ дамжуулах хоолойг Эрхүү, Красноярск, Саха гэсэн нэгдмэл эрчим хүчний төвөөс түүхий эдээр хангах нь чухал гэсэн байр суурьтай байгаа. Өөрөөр хэлбэл, Красноярск-Эрхүү-Саха-Зүүн Ази гэсэн дамжуулах хоолойг чухалчилж байна. Гэхдээ тэд “ГАЗПРОМ”-ын санал болгож байгаа Баруун Сибирь-Дорнод Сибирь-Монгол-БНХАУ гэсэн 6000 км урттай дамжуулах хоолойг “дараагийн ээлжинд” хэрэгжүүлэх нь зүйтэй гэж байгаа. 2002 онд ОХУ-ын Засгийн газраас баталсан “ОХУ-ын эрчим хүчний стратеги -2020 он” гэсэн баримт бичигт Дорнод Сибирь, Алс Дорнодын бүсэд байгалийн хийн олборлолтын шинэ том төвийг байгуулахаар заасан. Японы талаас Оросын дараах төслүүдийг санхүүжүүлэхэд оролцож болохоо мэдэгдсэн. Үүнд: Агнуурын тэнгисийн шельфийг эзэмших (100 сая ам.доллар), Якут-Сахалин-Япон гэсэн чиглэлд жилд 30 тэрбум квт/ц цахилгаан дамжуулах шугам, Байгалийн хийн дамжуулах хоолой барих (1 тэрбум 400 сая.ам доллар)

“Манай экспортын эрчим хүчний дөнгөж 3 хувь нь Азийн орнуудад ногддог. 10-15 жилийн дараа энэ үзүүлэлт 30 хувьд хүрнэ. Бид Зүүн болон Баруун Сибириэс хоёр ч дамжуулах хоолой барихаар төлөвлөж байгаа. Мэргэжилтнүүд энэ хоолойг хаагуур татахыг судлаж байгаа. Жилд 50-80 сая.тн нефть дамжуулах чадалтай хоолойг барьж эхэлсэн. Энэ хоолой Хятадын хилээс 150 км-т орших Сковородино хүртэл тавигдах юм. Сковородиногоос Номхон далай хүртэл тээвэрлэх асуудлыг Японтой ярилцаж байгаа. Зүүн Сибириг нефтийн хайгуулын ажлыг эрчимжүүлэх шаардлага гарч байна. “Нефть, хийн эрчим хүч нь олон улсын бодлогод үргэлж эмзэг асуудал байсаар ирсэн. Ойрхи Дорнод, Иранд үймээн самуунтай байна, энэ нь дэлхий дээрх эрчим хүчний асуудлыг хурцатгаж байна. Дэлхий нийт ОХУ-ыг найдвартай түнш, тогтвортой нефть нийлүүлэгч байгаасай гэж хүсдэг”⁴ гэсэн ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины ярилцлагад Сибирь, Алс Дорнодын нефть, хийн салбарын ойрын ирээдүйн хөгжлийг тодорхойлсон.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Геологийн нэвтэрхий толь., М., 2000 он, 451 т.
2. Мөн тэнд. 457 т.
3. Зууны мэдээ, №221, 2006 оны 9 дүгээр сарын 14
4. Зууны мэдээ, №221, 2006 оны 9 дүгээр сарын 14